


Баянзүрх дүүргийн Засаг даргын
2024 оны 08 дугаар сарын 30-ны
өдрийн 1531 дугаар захирамжийн
хоёрдугаар хавсралт



“БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН XII НААДАМ” НЭГДСЭН УДИРДАМЖ

Нэг.Зорилго

1.1.Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийг үндэслэн, Биеийн тамир, спортыг хөгжүүлэх, Нийслэл, дүүргийн нийгэм, эдийн засгийн зорилтын биелэлтийг хангах, “Биеийн тамир, спортыг айл өрх, иргэн бүрд” уриатайгаар Баянзүрх дүүргийн иргэдийг биеийн тамир, спортын уралдаан тэмцээнд өргөнөөр хамруулах, хороо, хэсгийн биеийн тамир спортын үйл ажиллагааг идэвхжүүлэх, иргэдийг эрүүл зөв амьдрах хэм хэмнэлд сургах, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, спортын амжилтыг ахиулахад тэмцээний зорилго оршино.

Хоёр.Наадмын зохион байгуулалт, удирдлага

2.1.Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар, Биеийн тамир спортын хороо, дүүргийн хороод нэгдсэн удирдамжийн дагуу наадмын үйл ажиллагааг хамтран зохион байгуулна.

Гурав.Наадам зохион байгуулагдах хугацаа, үе шат, оролцогчид

3.1.Наадмыг 5 үе шаттайгаар зохион байгуулна.

I шат:Хорооны хэсгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2024 оны 08 дугаар сарын 13-наас 09 дүгээр сарын 03-ны өдрийг хүртэл зохион байгуулна.

II шат:Хороодын аварга шалгаруулах тэмцээнийг 2024 оны 09 дүгээр сарын 04-нөөс 09 дүгээр сарын 17-ны өдрийг хүртэл зохион байгуулна.

III шат:Бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг 2024 оны 09 дүгээр сарын 30-наас 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл зохион байгуулна.

IV шат:Дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг 2024 оны 09 дүгээр сарын 09-нөөс 11 дүгээр сарын 12-ны өдрийг хүртэл зохион байгуулна.

V шат:Дүүргийн аварга шалгаруулах тэмцээнээс шалгарсан баг тамирчид Нийслэлийн аварга шалгаруулах тэмцээнд оролцоно.

3.2.Багийн бүрэлдэхүүнд тухайн хорооны иргэн байх бөгөөд хороо бүрээс тухайн спортын төрлөөр тэргүүлсэн, шигшээ баг, бүсийн тэмцээнд оролцоно.

3.3.Иргэдийн спортын XII наадмын нэгдсэн техникийн зөвлөгөөнийг 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 13:00 цагаас Баянзүрх дүүргийн 5 дугаар хорооны Иргэний танхимд зохион байгуулагдана.

Дөрөв.Арга хэмжээнд оролцогчдод тавигдах шаардлага

4.1.Дүүргийн Иргэдийн Спортын наадамд оролцох тамирчид 31 ба түүнээс дээш настай Баянзүрх дүүргийн иргэн байна. Тамирчдын насны ангиллыг төрсөн жилээр тооцож оролцуулна. (1993 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс өмнө төрсөн)

4.2.Багийн бүрэлдэхүүнд тухайн хорооны иргэн байх ба иргэний үнэмлэхийн хуулбар, E-MONGOLIA цахим мэдээллийн сангаас оршин суугаа хаягийн лавлагаа, иргэний үнэмлэхийн лавлагааг авч наадамд оролцоно. (цахим иргэний үнэмлэхээ хаясан тохиолдолд Улсын бүртгэлийн лавлагааг үндэслэн тэмцээнд оролцуулна)

4.3.Тухайн төрлийн спортын дэд мастер болон түүнээс дээш цолтой 31-44 насны тамирчин оролцохгүй, 45 болон түүнээс дээш настай тамирчид оролцож болно. Цол зэрэгтэй тамирчдыг Sport.gov.mn/ сайт болон бусад холбогдох нөхцөлөөр шалгана.

4.4.Нэг тамирчин спортын нэг төрөлд оролцоно. Спортын төрөлд давхцаж оролцохгүй.

4.5.Баг тамирчид тухайн спортын дүрэмт хувцас болон жигд формтой байна. (байгууллагын нэр логотой байх)

4.6.Баг тамирчид бүх шатны арга хэмжээнд, үндсэн бүрэлдэхүүнээрээ оролцоно.

4.7.Тамирчдын зардал, эрүүл мэнд болон бусад холбогдох асуудлыг тухайн хороо байгууллага бүрэн хариуцна.

4.8.Тамирчдын шилжилт хөдөлгөөн 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрөөс өмнө хийгдсэн байна.

4.9.Биеийн тамир, спортын хорооноос гаргасан нэгдсэн зааврыг зөрчсөн тохиолдолд тэмцээнд оролцох эрхийг хасна. Зөрчил гаргасан хороонд торгуулийн 20 оноо өгнө.

4.10.Спортын төрөл тус бүрийн зохион байгуулалт, нэмэлт шаардлагатай дүрэм, журам, өөрчлөлтийг тухайн арга хэмжээний техникийн зөвлөгөөн дээр шийднэ.

Тав.Иргэдийн спортын наадмын төрөл, тэмцээний заавар

5.1.Сагсан бөмбөг

5.1.1.Сагсан бөмбөгийн тэмцээнд баг тус бүр 12 эрэгтэй, 12 эмэгтэй, 1 дасгалжуулагчтай нийт 13 хүний бүрэлдэхүүнтэй байна.

5.1.2.Багийн бүрэлдэхүүнд 31-40 настай 6 тамирчин, 41 ба түүнээс дээш настай 6 хүний бүрэлдэхүүнтэй байна.

5.1.3.Тэмцээний 1 дүгээр үед 31-40 насны тамирчид, 2 дугаар үед 41-ээс дээш насны тамирчид тоглоно. 3, 4 дүгээр үед 41-ээс дээш насны 2-оос доошгүй тамирчид талбайд тоглоно.

5.1.4.Баг 2 ээлжийн жигд хувцастай байна.

5.2.Волейбол

5.2.1.Волейболын тэмцээнд баг тус бүр 8 эрэгтэй, 8 эмэгтэй, 1 дасгалжуулагч нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй байна.

5.2.2.Багийн тамирчид 31-ээс дээш настай байна.

5.3.Софт волейбол

5.3.1.Софт волейболын баг 3 эрэгтэй, 3 эмэгтэй нийт 6 тамирчны бүрэлдэхүүнтэй, насны ангилал нь 55 ба түүнээс дээш настай байна.

5.3.2.Талбай дээр 2 эрэгтэй, 2 эмэгтэй тамирчид тоглоно.

5.3.3.Талбайн хэмжээ 13.4*6.1м, дунд шугам 1.98м, торын өндөр 2м, бөмбөг нь зориулалтын тусгай уян зөөлөн резин эдлэлээр хийгдсэн, тойргийн хэмжээ 78 (+/-1) см, жин 210(+/-10) грамм байна.

5.4.Олс таталт

5.4.1.Олс таталтын тэмцээнд баг тус бүр гарааны 9 эрэгтэй, 9 эмэгтэй тамирчин, 1 дасгалжуулагчтай нийт 10 хүний бүрэлдэхүүнтэй байна.

5.4.2.Эрэгтэй багийн 8 хүний нийт жин 640 кг, эмэгтэй багийн 8 хүний нийт жин 520 кг жинтэй байна. Орлон тоглогч багийн хамгийн бага жинтэй байна.

5.4.3.Багийн 8 хүний нийт жин хэтэрсэн тохиолдолд 7-оос доошгүй хүний бүрэлдэхүүнтэйгээр тэмцээнд оролцож болно. Тэмцээн эхлэхээс 1-2 цагийн өмнө хяналтын жин хийгдэнэ.

5.5.Ширээний шагайн наадгай

5.5.1.Ширээний шагайн наадгайн тэмцээнд баг тус бүр 7 эрэгтэй, 7 эмэгтэй, 1 дасгалжуулагчийн бүрэлдэхүүнтэй оролцоно.

5.5.2.Багийн 7 хүний бүрэлдэхүүнд 31 ба түүнээс дээш насны 4 тамирчин, 51 ба түүнээс дээш насны 3 тамирчин байна.

5.5.3.Тэмцээнийг эрэгтэй, эмэгтэй ангиллаар тус бүр 3 төрлөөр зохион байгуулж, нийлбэр оноогоор дүгнэнэ.

а/Шагай няслах-Эхний хүн 30 ширхэг шагай орхиж, түүнээс няслан авсан шагайн тоогоор оноо авна. Дараагийн хүн дээрх үйлдлийг давтах хэлбэрээр гүйцэтгэж багийн 7 гишүүний няслан авсан шагайн тоон нийлбэрээр дүнг гаргана. (1 шагай 1 оноо)

б/Шагай атгах-30 ширхэг шагайгаар сүрэг нийлж, тойргоор сүрэг дуустал тоглож, авсан шагайн тоогоор оноо авна. (1 шагай 1 оноо)

Жишээ нь: Эрэгтэй 17 ширхэг шагай, эмэгтэй 12 шагай багцална. Хэрэв багцалсан шагайг бүтэн тойрог тоглоод авч чадахгүй үед 1 сүүл (1 шагай) авах журмаар 3 удаа тойрно. Эрэгтэй 9 шагай, эмэгтэй 6 шагайг 3 товшиж авна. Тойроод авч чадаагүй тохиолдолд 2 товшиж авна. 10 ширхэг шагай таслаад 6 шагай шүүрвэл, шүүрсэн шагайгаа тоолуулан оноогоо авч дараагийн оролдлого хийнэ.

в/Морь уралдуулах - Тэмцээнд оролцогч багийн төлөөлөл, морь уралдуулах ширээнд эгнэн зогсож морь уралдуулна. Түрүүлсэн тохиолдолд 23 оноо, зэрэгцэн орсон тохиолдолд зөв талын морийг түрүүлсэнд тооцно. Бусад тамирчдын морьд байрандаа тоолуулж 1-21 оноо авна. 1 хүн 4 ширхэг шагайг орхиж, морь буусан тохиолдолд нэмэлт 1 удаа орхих эрх авна.

5.6.Хийн дасгал

5.6.1.Баг нь 12 хүний бүрэлдэхүүнтэй байна. Багт 45 ба түүнээс дээш насны 12 тамирчин, 3-аас доошгүй эрэгтэй тамирчинтай байна.

5.6.2.Хийн дасгалын тэмцээнийг Монголын Хийн дасгалын холбооноос боловсруулан гаргасан Бие чийрэгжүүлэх "ТАВАН АМЬТАН"-ны дасгалаар зохион байгуулна.

5.6.3.Дасгалын гүйцэтгэл, ур чадвар, жигдрэл, хувцаслалт зэргийг харгалзан, үнэлгээ өгч дүгнэнэ.

5.7.Аэробик

5.7.1.Баг нь 31 ба түүнээс дээш насны 12 тамирчны бүрэлдэхүүнтэй байна. Багт 3-аас доошгүй эрэгтэй тамирчинтай байна.

5.7.2.Аэробикийн тэмцээнийг 2023 онд Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас баталсан дасгалаар зохион байгуулна. Дасгалыг “Нийслэлийн Биеийн тамир, спортын газар” пэйж хуудсанд байршуулна.

5.7.3.Дасгалын ур чадвар, гүйцэтгэл, хувцасны жигдрэлт зэргийг харгалзан үзэж, үнэлгээ өгнө.

5.8.Дартс

5.8.1.Дартсын тэмцээнд эрэгтэй дан хос, эмэгтэй дан хос, багийн (эр-2, эм-2) гэсэн 3 төрлөөр зохион байгуулна.

5.8.2.Эрэгтэй, эмэгтэй дан хос тус бүр 31 ба түүнээс дээш настай 1 тамирчин, 50 ба түүнээс дээш настай тамирчин тус бүр 1 байна. Багийн төрлийн бүрэлдэхүүн 4 (эр-2, эм-2) багт 50 ба түүнээс дээш насны 1 тамирчин байна.

5.8.3.Тоглолтыг 501 онооноос хасаж тоглох ба 2-н үржвэрээр тэглэж төгсгөнө.

Хэрвээ 2-ын үржвэр оноогүй тохиолдолд бухын нүдэнд хамгийн ойрхон шидсэн нь хожлыг авна.

5.9.Спорт явган аялал

5.9.1.Баг нь 6 эрэгтэй, 6 эмэгтэй, 1 дасгалжуулагч нийт 13 бүрэлдэхүүнтэй байна.

5.9.2.Баг нь хорооны онцлогийг харуулсан хаяг, эмблем, жигд хувцастай байна.

5.9.3.Спорт явган аяллын тэмцээнийг аялал, алхалт, газрын зураг дээр ажиллах, нуувч илрүүлэх гэх мэт төрлүүд дээр зохион явагдана.

5.9.4.Тэмцээнийг дүгнэх үзүүлэлтүүд:

- Тэмцээний нээлт, хаалтын ажиллагааны ирц.
- Аяллын явц, цуваанд явсан сахилга бат, багийн зохион байгуулалт.
- Багийн болон хувь хүний бэлтгэл.
- Галын болон отгийн ариун цэвэр, эко байдал.
- Эмийн сангийн бүрдэл.
- Аяллын тэмдэглэл, хөтлөлт.
- Нэмэлт галын наадам, урлагийн тоглолт, бэлэг дурсгалын зүйл солилцох.

5.9.5.Байгууллагын дүнг: Багуудын аялал, тэмцээнд оролцсон амжилт болон нийт аяллын явцад баг тамирчдыг хэрхэн зохион явуулсан байдал, идэвх оролцоо, санаачилга зэргийг харгалзан үзнэ.

Жич:Спорт явган аяллын техникийн зөвлөгөөнийг 2024 оны 08 дүгээр сарын 23-ны 12:00 цагт Баянзүрх дүүргийн Биеийн тамир спортын хорооны 314 тоот өрөөнд болно.

Зургаа.Мэдүүлэг хүлээн авах журам, хугацаа, бүрдүүлэх материал

6.1.Биеийн тамир, спортын хорооноос гаргасан загварын дагуу тэмцээнд оролцох багийн мэдүүлгийг төрөл тус бүрээр нь хийсэн байх шаардлагатай.

6.2.Мэдүүлэгт тавигдах шаардлага:

- Хорооны Засаг даргын гарын үсэг тамгаар баталгаажуулж, багийн ахлагч, дасгалжуулагч хянасан байх;
- Овог, нэр бүтэн бичигдсэн байх;

- Регистрийн дугаар;
- Цээж зураг, сүүлийн 6 авхуулсан, танигдахуйц байх;
- Гэрийн хаяг;
- Багийн ахлагч, дасгалжуулагчийн овог нэр бичигдсэн байх;
- Эмчийн гарын үсэг, тамгаар баталгаажсан байх; (тамирчин эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байх)
- Бичиг баримт боловсруулах стандартын дагуу бичих; (шаардлага хангаагүй мэдүүлгийг хүлээн авахгүй)

6.3.Мэдүүлэгт бүх тамирчдын иргэний үнэмлэхийн хуулбар, E MONGOLIA цахим мэдээллийн сангаас оршин суугаа газрын лавлагаа болон иргэний үнэмлэхийн лавлагааг заавал хавсаргана.

6.4.Бүх тэмцээний мэдүүлэг авах хугацааг техникийн зөвлөгөөн дээр эцэслэн шийдвэрлэнэ.

Долоо.Дүгнэх журам

7.1.Наадмын нэгдсэн дүнг тухайн спортын төрөл тус бүрийн амжилтыг их онооны системээр дүгнэнэ.

7.2.Дүүргийн аварга шалгаруулах тэмцээнд баг тамирчдаа удирдамжийн 4 дүгээр зүйлд заасны дагуу зохион байгуулалт дэг журамтай оролцуулсан байдлыг харгалзан оноо өгч дүгнэнэ. (5, 10, 15, 20 оноо)

Найм.Шагнал урамшуулал

8.1.Дүүргийн аварга шалгаруулах тэмцээнд спортын төрөл тус бүрд амжилттай оролцсон баг тамирчдад алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж, урамшуулна.

8.2.Нийлбэр дүнгээр эхний 3-н байр эзэлсэн хороодод өргөмжлөл, цом, мөнгөн шагналаар шагнана. Төрөл тус бүрд аварга болсон баг (хороо) Нийслэлийн шигшээ тэмцээнд оролцох эрхээ авна.

ИРГЭДИЙН СПОРТЫН XII НААДМЫН БҮСИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ХУВААРЬ

№	I бүс	II бүс	III бүс	IV бүс
1	1-р Хороо	4-р хороо	6-р Хороо	12-р Хороо
2	2-р Хороо	5-р Хороо	37-р хороо	10-р Хороо
3	3-р Хороо	22-р Хороо	15-р Хороо	23-р Хороо
4	7-р Хороо	16-р Хороо	18-р Хороо	28-р Хороо
5	21-р Хороо	19-р Хороо	25-р Хороо	20-р Хороо
6	27-р Хороо	9-р Хороо	26-р Хороо	11-р Хороо
7	29-р Хороо	17-р Хороо	13-р Хороо	33-р Хороо
8	30-р Хороо	24-р Хороо	36-р Хороо	35-р Хороо
9	31-р Хороо	34-р Хороо	42-р Хороо	8-р Хороо
10	32-р Хороо	40-р Хороо	43-р Хороо	38-р Хороо
11	41-р Хороо	14-р Хороо		39-р Хороо

Тэмцээн зохион байгуулагдах хугацаа байршил			
127, 137-р сургууль 2024 оны 09 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд	69 А, Б заал сургууль 2024 оны 09 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд	79, 92-р сургууль 2024 оны 09 дүгээр сарын 28-29-ний өдрүүдэд	87, 120-р сургууль 2024 оны 09 дүгээр сарын 28-29-ний өдрүүдэд
Зохион байгуулагдах төрөл			
Сагсан бөмбөг Волейбол	Сагсан бөмбөг Волейбол	Сагсан бөмбөг Волейбол	Сагсан бөмбөг Волейбол
Хариуцах байгууллага, хамтран зохион байгуулах хорооны Засаг дарга, сургуулийн захирал			
БТСХ Биеийн тамирын хэлтэс 21-р хорооны Засаг дарга Н.Эрдэнэзаяа 127-р сургуулийн захирал С.Хүрэлбаатар 137-р сургуулийн захирал Ц.Буйданбаатар	БТСХ Биеийн тамирын хэлтэс 22-р хорооны Засаг дарга Х.Батжаргал 69-р сургуулийн захирал Ш.Оюунсайхан	БТСХ Биеийн тамирын хэлтэс 36-р хорооны Засаг дарга Г.Мядагцэцэг 79-р сургуулийн захирал У.Дугармаа 92-р сургуулийн захирал Б.Болортуяа	БТСХ Биеийн тамирын хэлтэс 20-р хорооны Засаг дарга Ц.Гомбосүрэн 87-р сургуулийн захирал Л.Алтаншагай 120-р сургуулийн захирал Ю.Базарханд

**ИРГЭДИЙН СПОРТЫН XII НААДМЫН ДҮҮРГИЙН АВАРГА
ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ХУВААРЬ**

№	Тэмцээний төрөл	Жин,зай,төрөл	Хугацаа	Явагдах газар	Хариуцах эзэн
1	2	3	4	5	6
1	Волейбол	эрэгтэй 8, эмэгтэй 8, 1 дасгалжуулагч	2024 оны 11 дүгээр сарын 2-3	88 дугаар сургуулийн спорт заал	88-р сургуулийн захирал Ч.Уранбаяр БТСХ мэргэжилтэн О.Түмэнжаргал
2	Олс таталт	эрэгтэй 9, эмэгтэй 9, 1 дасгалжуулагч	2024 оны 09 дүгээр сарын 14-15	97 дугаар сургуулийн хөлбөмбөгийн талбай	97-р сургуулийн захирал Г.Баярмаа БТСХ мэргэжилтэн И.Бат-Эрдэнэ
3	Сагсан бөмбөг	эрэгтэй 12, эмэгтэй 12, 1 дасгалжуулагч	2024 оны 10 дугаар сарын 26-27	Амгалан сургуулийн спорт заал	Амгалан сургуулийн захирал Л.Баяртуул БТСХ БТХ-ийн дарга С.Сувд
4	Шагайн наадгай	эрэгтэй 7, эмэгтэй 7, 1 дасгалжуулагч	2024 оны 10 дугаар сарын 06	102-р сургуулийн спорт заал	102 дугаар сургуулийн захирал Г.Гүнбаяр БТСХ мэргэжилтэн Н.Сэмжид
5	Хийн дасгал	12 тамирчинтай байх ба багт 31- 50 насны 4, 51 ба түүнээс дээш насны 8 тамирчин, зааварт заагдсан нас харгалзахгүй 3-с доошгүй эрэгтэй тамирчинтай байна	2024 оны 10 дугаар сарын 05	111 дүгээр сургуулийн спорт заал	111-р сургуулийн захирал Э.Галхүү БТСХ мэргэжилтэн Н.Сэмжид
6	Аэробик	31 ба түүнээс дээш насны 12 тамирчинтай байх ба багт 3-с доошгүй эрэгтэй тамирчинтай байна	2024 оны 10 дугаар сарын 12	111 дүгээр сургуулийн спорт заал	111-р сургуулийн захирал Э.Галхүү БТСХ мэргэжилтэн Н.Сэмжид

№	Тэмцээний төрөл	Жин, зай, төрөл	Хугацаа	Явагдах газар	Хариуцах эзэн
1	2	3	4	5	6
7	Софт волейбол	эрэгтэй 3, эмэгтэй 3 1 дасгалжуулагч	2024 оны 10 дугаар сарын 05-06	155 дугаар сургуулийн спорт заал	155-р сургуулийн захирал Д.Болд БТСХ мэргэжилтэн Э.Уянга
8	Дартс	эрэгтэй 2, эмэгтэй 2 эрэгтэй дан хос эмэгтэй дан хос	2024 оны 10 дугаар сарын 05	44 дүгээр сургуулийн спорт заал	44-р сургуулийн захирал Ж.Чимэдзаяа БТСХ мэргэжилтэн Г.Билгүүн
9	Спорт явган аялал	эрэгтэй 6, эмэгтэй 6, 1 дасгалжуулагч	2024 оны 08 дугаар сарын 30-31	Жанжны буйраас-Хар усан тохой чиглэлд алхах	Биеийн тамирын хэлтсийн дарга С.Сувд